

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ**



**ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО, ЗАХИРГААНЫ ХООРОНД БАЙГУУЛСАН
ХАМТЫН ГЭРЭЭ**

Хувилбарын дугаар: 02

Хүчин төгөлдөр болсон огноо: 2026-01-01

Баримт бичгийн дугаар

2026 он

ХӨРӨӨ
ХӨРӨӨ

ХӨРӨӨ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол улсын хөдөлмөрийн тухай, ХАБЭА-н тухай болон ҮЭ-үүдийн эрхийн тухай, Монгол Улсын хуулиудыг үндэслэн нэг талаас БОЭТөвийн захиргаа, нөгөө талаас БОЭТөвийн нийт ажилчдыг төлөөлж ҮЭХ-ны төлөөлөл харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2. Энэхүү хамтын гэрээ нь манай эмнэлгийн байгууллагад ажиллагсадын хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах болон хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэх хууль эрх зүйн баримт бичиг болно.
- 1.3. Энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс өмнө байгуулагдсан бүх хөдөлмөрийн гэрээний заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах буюу шинэчлэн байгуулна.
- 1.4. Талууд гэрээнд заасан аливаа асуудалд харилцан тэгш эрхтэй оролцоно.
- 1.5. Ажилтны төлөөлөгч хамтын гэрээ хэлэцээрийн заалтыг биелүүлэх талаар шаардлага тавьж хөдөлмөрийн хамтын маргаан үүсгэх эрхийг эдэлнэ.
- 1.6. Байгууллагын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх үед ажилтан хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах эрх эдлэх ба талууд аливаа улс төрийн хүчний нөлөөлөлд автахгүй байна. Ажил олгогчийн харъяалал, удирдлагын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь гэрээг цуцлах үндэслэл болохгүй бөгөөд хэрэгжилтийг хангах үүргийг үргэлжлүүлэн авч гүйцэтгэнэ.

- 1.7. Зөвхөн татвар төлж байгаа гишүүн бүрт тэгш үйлчлэнэ.

ХОЁР . АЖИЛ ЭРХЛЭЛТ , АЖЛЫН БАЙРНЫ БАТАЛГАА

- 2.1 Ажил олгогч нь үйлдвэрлэл үйлчилгээг тасралтгүй хэвийн явуулах нөхцөл бүрдүүлж ажиллагсадыг ажлаар бүрэн хангана.
- 2.2 Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд хөдөлмөрийн тухай хуулийн 82-р зүйлд заасан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсаны тэтгэмжийг олгоно.
- 2.3 Үндсэн ажлаасаа чөлөөлөгдсөн ҮЭ-н сонгууль ажилтны ажил, албан тушаалыг ажил олгогч уг сонгуулийн хугацаа дуусгавар болох хүртэл хадгалах бөгөөд сонгуулийн хугацаа нь дуусгавар болсон, түүнчлэн хугацаанаасаа өмнө сонгуульт үүргээсээ чөлөөлөгдсөн тохиолдолд түүнийг хуучин ажилд нь эргүүлэн ажиллуулах буюу тухайн ажил байхгүй бол өөрийнх нь зөвшөөрсөнөөр урьд авч байсан цалин хөлс нь буурахгүйгээр өөр ажил олгоно.
- 2.4. Эрүүл мэндийн яам болон мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан заавар зөвлөмжийг үндэслэн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг эмч ажиллагсдад ажлын цагийг богиносгох ажлын нөхцлийн нэмэгдэл олгох, хор саармагжуулах шингэн олгох зэрэг хөнгөлөлтийн аль тохирохыг эдлүүлнэ.
- 2.5. Эмнэлгийн бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орох тохиолдолд ажилтаны орон тоог цөөрүүлсэн, эсвэл мэргэжил ур чадвар, эрүүл мэндийн улмаас ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон үндэслэлээр ажил олгогчийн санаачлагаар ажлаас чөлөөлөх тохиолдолд энэ тухайгаа ажилтанд нэг сарын өмнө бичгээр мэдэгдэж ажилтны хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгохдоо ҮЭХ-той зөвшилцөн шийдвэрлэнэ.
- 2.6 Байгалийн онц аюултай үзэгдэл (ширүүн аадар бороо, үер, зуд, цасан болон шороон шуурга, хэт хүйтрэлт, халалт, гал, түймэр)-н үеэр онцгой байдал зарлагдсан үед эмч мэргэжилтнүүдийг аль болох алсын дуудлаганд явуулахгүй байх, дуудлагыг эрэмбэлж зохицуулах, зайлшгүй шаардлагаар томилон явуулах бол дуудлаганд явж ирэх хугацаанд эмч мэргэжилтнүүд жолооч нарын амь нас, эрүүл мэндийн баталгааг хангаж явуулна. / Машин техникийн бүрэн бүтэн байдал, бензин шатахууны хангалт, холбоо барих хувцас хамгаалах хэрэгсэл гэх мэт/
- 2.7 Ажил үүргийн онцлогоос шалтгаалан завсарлах боломжгүй ээлжийн ажилтай

- 2.8 Техник технологийн дэвшлийг ашиглан БОЭТөвийн хүний нөөцийг бууруулах, ховор нарийн мэргэжлийн ур чадврыг орон нутагт ашиглах, шинэ технологи иновацийг нутагшуулах чиглэлээр эмч мэргэжилтнийг зайнаас ажиллуулах тохиолдолд хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулна.

ГУРАВ. ЦАЛИН ХӨЛСНИЙ ТАЛААР

- 3.1. Ажил олгогч нь ажилтнуудын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, унаа хоолны зардал болон бусад нөхөн олговрын хэмжээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, Засгийн газрын тогтоол болон хамтын гэрээгээр зохицуулж, өмнөх хүрсэн түвшингээс бууруулахгүй ажиллана.
- 3.2. Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ ажил, албан тушаал хавсран, хослон ажилласан бол 40% хүртэл, ажлын 10 хоногоос дээш хугацаагаар өвчтэй, цалингүй чөлөө авсан тохиолдолд эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, албан тушаалын тодорхойлолтонд заагаагүй ажил үүрэг гүйцэтгэсэн бол ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцож үндсэн цалингийн 30% хүртэл, тус тус тооцон нэмэгдэл хөлс олгоно.
- 3.3. Монгол улсын Засгийн газрын 2019 оны 01 сарын 09-ны 5-р тогтоолын 3-р хавсралтад зааснаар ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журамд заасны дагуу улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг ажилтны 1 сарын үндсэн цалин, хөлсний хэмжээнээс тооцож, ажил олгогч нийт ажиллагсдад улирал бүр олгоно. Энэ зохицуулалт тэтгэвэр авагч ахмад ажилтанд мөн адил хамаарна. Энэхүү урамшууллыг сахилгын шийтгэл зөрчил гаргасан ажиллагсдад сахилгын шийтгэлийн ногдуулсан хугацаанд олгохгүй ба УЗ-ийн хурлаар хэлэлцүүлэгдэн Захирлын тушаалаар сахилгын шийтгэлгүй хүчингүйд тооцсон тохиолдолд үр дүн урамшууллыг олгоно.
- 3.4. Гамшгийн аюулт үзэгдэл, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийн улмаас, эсвэл ажилтнаас үл шалтгаалах сул зогсолтын хугацаанд түүнийг өөр ажилт шилжүүлэх боломжгүй бол түүнд үндсэн цалингийн 70% -с доошгүй хувьтай тэнцэх хэмжээний олговор олгох, олговрын хэмжээ нь хөдөлмөрийн хөлснөөс доогуур байж болохгүй. /ХТХ-116/ЭМС-н 2020-02-08ны А/69-р тушаалын хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажиллах.
- 3.5. Тухайн ажилтан ажлын цагт ажлын гүйцэтгэлийг давуулан биелүүлсэн тохиолдолд гүйцэтгэлийг үнэлэх шалгуурын дагуу нэмэгдэл олгож болно.
- 3.6. Эмч ажилчдын хөдөлмөрийн хөлсийг сард 2 удаа санхүүжилт орж ирснээс хойш ажлын 3 хоногийн дотор цалин хөлсийг олгоно. 3 хоногийн дотор олгоогүй тохиолдолд хөдөлмөрийн хуулийн дагуу арга хэмжээ авна.
- 3.7. Долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр, долоо хоногийн ажлын өдөр, ажлын бус цагаар, илүү цагаар ажилласан эмч ажиллагсдын илүү цагийн хөлсийг 2 дахин хүртэл нэмэгдүүлж олгоно. Шөнийн цагаар ээлжээр ажилласан эмч ажилтны шөнийн нэмэгдэл цагийн цалин хөлсийг хөдөлмөрийн тухай хуулийн дагуу олгоно. /ХТХ-109.3, 109.8/
- 3.8. Ажил олгогч нь ажилтанд жилийн ажлын үзүүлэлт, салбарын ойн баяр болон нийтээр тэмдэглэх баярыг тохиолдуулан мөнгөн шагналаар шагнах ба бусад төрлийн урамшуулал үзүүлнэ. Мөн ажил мэргэжлийн болзолт уралдаан зарлах, амжилт гаргасан ажилтныг тухайн болзлын дагуу шагнаж урамшуулна.
- 3.9. Нийтээр амрах баярын өдөр жижүүр хийсэн эмчийн цагийг 20 цагаар тооцож цалин хөлсийг олгоно
- 3.10. Бүр орон тоонд ажиллаж байгаа ажилтан цалингийн урьдчилгаа авах хүсэлт гаргавал 1 сар хүртэлх хугацааны үндсэн цалинг жилд 1 удаа олгоно.
- 3.11. Жижүүрийн ахлах эмчийн хариуцлагын урамшууллыг 10000 төгрөгөөр тооцож

ТҮЗ

ТУЗ

379

олгоно.

- 3.12. Ажил олгогчийн буруугаас гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлэх боломжгүй бол үндсэн цалингаас 60% дээш бодож олговор олгоно.
- 3.13. Эрүүл мэнд анагаах ухааны чиглэлээр эрдэм шинжилгээ , судалгааны ажил хийж магистр, докторын зэрэг хамгаалсан эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг тухайн жилд нь 1 удаа олгоно.
- 3.14. Ажил олгогч нь хариуцлагатай албанд хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 10 дээш хувиар, эд хариуцагч нарт үндсэн цалингийн 8-аас доошгүй хувийг нэмэгдэл хөлс олгоно.

ДӨРӨВ. АЖИЛ АМРАЛТЫН ЦАГ

- 4.1 Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллагсад долоо хоногийн ажлын 40 цаг ажлын өдрийн үргэлжлэл 8 цаг байна. Хэвийн бус нөхцөлд ажиллагсадын 7 хоногийн ажлын цаг 30-35 , 1 өдрийн ажлын үргэлжлэл 6-7 цаг байна.
- 4.2 Хөдөлмөрийн хэвийн, хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтан нь хөдөлмөрийн тухай хууль, эрүүл мэндийн тухай хууль , байгууллагын дотоод журамд заасны дагуу ажиллах ба ээлжийн ажлын цагийг харьяалах тасаг, албаны дарга эрхлэгч, ахлах сувилагч нар ээлжийн хуваариар долоо хоног, сараар зохицуулна.
- 4.3 Жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн эмч нар жижүүрт гарсан дараагийн өдөр нь ажлын өдөр байвал ажлын онцлог шаардлага гараагүй нөхцөлд Эмнэлзүй эрхэлсэн дэд захиралд эсвэл харьяалах тасгийн эрхлэгчид албан ёсоор мэдэгдэж буусан өдрөө 13 цагаас хойш 4 цаг биеэр амарна. Харин баасан, бямба гаригт жижүүрт хоносон эмчийн биеэр амрах өдөр амралтын өдөр байгаа тул биеэр нөхөж амрахгүй, ням гариг жижүүрт хоносон эмч даваа гаргийн 13 цагаас хойш 4 цаг биеэр амарна. Яаралтай зайлшгүй тусламж үйлчилгээ үзүүлэх шаардлага гарсны улмаас Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал албан ёсоор зөвшөөрөл өгч ажилласнаас бусад тохиолдолд нөхөн амралт олгохгүй;
- 4.4 Байгууллагын шаардлагаар байнга илүү цагаар ажилладаг эмч ажилчдын ажлын хоорондох амралтын хугацаа 12 цагаас доошгүй байх ба ажилтаныг 2 ээлжинд дараалан ажиллуулахыг хориглоно.
- 4.5 Эмч эмнэлгийн ажилтанд жил бүр оны эхэнд баталсан хуваариар ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр буюу ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна.
- 4.6 Хөгжлийн бэрхшээлтэй ажилтаны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна.
- 4.7 Ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 15 өдөр байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 29-7 дэх заалтаар ажилласан 5 жил тутамд нэг хоногийн нэмэгдэл олгох ба ажилтаны өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн жилдээ багтаан 2 хувааж олгож болно.
- 4.8 Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан үндсэн амралт дээр нь дор дурдсан нэмэгдэл олгоно:
 - а) 6-10 жилд ажлын 3 өдөр (61-120)
 - б) 11-15 жилд ажлын 5 өдөр (121-180)
 - в) 16-20 жилд ажлын 7 өдөр (181-240)
 - г) 21-25 жилд ажлын 9 өдөр (241-300)
 - д) 26-31 өдөр ажлын 11 өдөр (301-372)
 - е) 32 түүнээс дээш жилд ажлын 14 өдөр (373 ба түүнээс дээш сар)

4.9 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан үндсэн амралт дээр нь дор дурдсан нэмэгдэл олгоно:

- a) 6-10 жилд ажлын 5 өдөр (61-120)
- b) 11-15 жилд ажлын 7 өдөр (121-180)
- c) 16-20 жилд ажлын 9 өдөр (181-240)
- d) 21-25 жилд ажлын 12 өдөр (241-300)
- e) 26-31 өдөр ажлын 15 өдөр (301-372)
- f) 32 түүнээс дээш жилд ажлын 18 өдөр (373 ба түүнээс дээш сар)

ТАВ. МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ДАВТАН СУРГАХ ТАЛААР

- 5.1 Эмнэлгийн мэргэжилтэн нь байгууллагын саналаар үндсэн ажлаасаа түр чөлөөлөгдөн гадаад дотоодын болон төрийн сангийн сургалтанд (мэргэжил олгох, дээшлүүлэх) 90 хоног хүртэл хугацаагаар суралцаж буй тохиолдолд суралцсан хугацааг ажилласанд тооцон үндсэн цалинг олгоно. Онцгой шаардлагатай мэргэжлээр сургах тохиолдолд байгууллагын захиргаа ажилтан 2-ын хооронд хийсэн гэрээгээр зохицуулагдана.
- 5.2 Байгууллагын санаачилгаар Улаанбаатар хот болон бусад аймаг, хотод 90 хоног хүртэл хугацаагаар сургалтанд хамрагдахад ирэх очих замын зардлыг нийтийн тээврийн тарифаар тооцож байгууллага олгоно.
- 5.3 Ажиллагсдыг жилд 1 удаа ёс зүй, халдвараас сэргийлэх хяналт, ХАБЭА сургалтад ҮЭХ-ны зардлаар сургалт зохион байгуулна.

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР

- 6.1 Байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан алба эсвэл ажилтан ажиллуулна. Мөн ажил олгогч, ҮЭ-ийн төлөөлөл бүхий орон тооны бус зөвлөл ажиллуулна.
- 6.2 Ажилтны хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах бөгөөд ариутган угааж цэвэрлэнэ.
- 6.3 Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, гэмтэл, өвчлөлөөс ажилтаныг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар тусгай журам гаргаж мөрдөж ажиллана.
- 6.4 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд олгох нөхцлийн нэмэгдэл, цаг хорогдуулах ажилтануудын жагсаалтыг баталж мөрдүүлнэ (хавсралт)
- 6.5 Үйлдвэрийн осол, хурц хордлого мэргэжлээс шалтгаалах өвчнийг үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссоос тогтоосон тохиолдолд хөдөлмөрийн чадвараа 30 хувь хүртэл алдсан ажилтанд 5 сар, 31- 50 хувь хүртэл алдсан ажилтанд 7 сар, 51-70 хувь хүртэл алдсан ажилтанд 9 сар, 71 хувиас дээш алдсан ажилтанд 18 сарын цалингийн дундажтай тэнцэх хэмжээний, дээрхи шалтгаанаар нас барсан ажилтаны ар гэрт 36 сарын цалинтай тэнцэх нөхөн төлбөрийг нэг удаа байгууллагаас олгоно.
- 6.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийг үндэслэн ажлын байрны нөхцлийн үнэлгээг 2 жилд нэг удаа мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
- 6.7 БОЭТөв нь төсвийн хөрөнгөөр нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний зардлын 0.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн осол хурц хордлого мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалтанд зарцуулна.
- 6.8 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтаныг ажлын чиглэлээр сургалтанд хамруулна.
- 6.9 Хөдөлмөр хамгааллын хувцасны зардлыг төсөвт тусган 2 жилд 1 доошгүй ээлжийн хувцсаар хангана.

- 6.10 Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн шаардлагыг хангасан ажлын байраар хангах үүргийг хүлээж , ажилтан нь ажлын ая тухтай байдалд анхааран эрүүл ахуй , ариун цэврийн шаардлагыг бүрэн ханган ажиллана.

ДОЛОО. ЭМЧ АЖИЛЛАГСДАД ЧӨЛӨӨ ОЛГОХ ТАЛААР

- 7.1 Эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол шинээр хамгаалах, резидентурын шалгалт өгөх 10 өдөр, эмч, эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн зэрэг хамгаалах, үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн элсэлтийн шалгалтанд орох үед ажлын 7 өдрийн цалинтай чөлөөг 1 удаа олгоно.
- 7.2 Анагаах ухааны болон шинжлэх ухааны магистр, доктор хамгаалах үед 10 өдрийн цалинтай чөлөө олгоно.
- 7.3 Эмнэлгийн мэргэжилтэн өөрийн мэргэшлийн чиглэлээр байгууллагын захиалгаар гадаадад сургалт, семинарт оролцох тохиолдолд 7-90 хоног хүртэлх цалинтай чөлөө олгоно.
- 7.4 Эхнэр нь амаржсан 10 , гэр бүл болж хурим хийх үед 5 хоногийн (шинэ гэр байшинд анх удаа орох үед ажлын 3 өдрийн цалинтай чөлөөг) тухайн 7 хоногт олгоно.
- 7.6 Эхнэр нь 2 ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлсэн тохиолдолд ажлын 15 өдөр цалинтай чөлөө / тухайн үед нь / олгоно.
- 7.7 Үр хүүхэд нь гэр бүл болж хуримлах тохиолдолд ажлын 3 өдөр цалинтай чөлөө олгоно. /Тухайн үед/
- 7.8 Эхнэр, нөхөр, төрсөн болон үрчилсэн эцэг эх, үр хүүхэд нь маш хүндээр өвдсөн тохиолдолд жилд 1 удаа ажлын 5 өдөр цалинтай чөлөө олгоно.
- 7.9 Гэр бүлийн гишүүн нь /эхнэр,нөхөр, хүүхэд/ төрсөн болон хадам аав,ээж, нас барсан үед ажлын 5 өдрийн, өөрийн өвөө, эмээ, төрсөн ах ,эгч, дүү нь нас барсан үед ажлын 3 өдрийн цалинтай чөлөөг эмнэлгийн бичиг баримтыг үндэслэн /тухайн үед нь / олгоно.
- 7.10 Хүнд өвчтэй гэр бүлийн гишүүн өөрийн болон хадам эцэг, эх төрсөн ах,эгч, дүү зэргийг зайлшгүй шаардлагаар сахиж асрамжлах үед 3 сар хүртэл цалингүй чөлөө өгч болно.
- 7.11 Орой, эчнээ сургуульд элсэх,суралцах,өвчний заалтаар рашаан сувилалд амрах үед чөлөө олгохдоо ээлжийн амралтаас тооцох ба амралтаа эдэлсэн нөхцөлд ажилтаны хүсэлт, сургуулийн захиргааны тодорхойлолт, бусад баримт бичгийг үндэслэн 3 сар хүртэл цалингүй чөлөө олгож болно.

НАЙМ. ЭМЧ АЖИЛЧДАД БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРГААНААС ҮЗҮҮЛЭХ НИЙГЭМ АХУЙН ХӨНГӨЛӨЛТ (ТЭТГЭМЖ,ТУСЛАМЖ,УРАМШУУЛАЛ)

- 8.1 Эмнэлгийн ажилтаны онош тодорхойгүй болон биеийн байдал хүндэрч орон нутгийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт эмчлэгдэж байгаа тохиолдолд өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ хийх ба эмчилгээний тусламж үзүүлэх, Улаанбаатар хотод 3 дахь шатлалын эмнэлэгт эмчлүүлэхэд нь өөрийн болон 1 асран харгалзагчийн 2 талын замын зардлыг олгоно.
- 8.2 Эмнэлгийн ажилтан өөрөө нас барахад хүндэтгэл үзүүлж хууль тогтоомжийн дагуу тэтгэмж олгоно .
- 8.3 Ахуй амьдрал нь хүндэрсэн өндөр настанд мөнгөн болон эд материалын тусламж үзүүлнэ.
- 8.4 Өөрийн байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт тогтоолгосон өндөр настан нас барахад 300000 төгрөгний тусламж өгнө.
- 8.5 Шинэ гэр бүл болох, анх удаа шинээр гэр,байшин барих, орон сууцанд ороход хүндэтгэл үзүүлнэ. Нэг гэр бүлийн хүмүүс ажиллаж байгаа тохиолдолд адил хамаарна.
- 8.6 Анхны хүүхдээ төрүүлсэн өрхийн (хүүхэд төрснөөс 3 сарын дотор) хүүхдэд нь 50000 төгрөгний хадгаламж нээж өгнө.
- 8.7 Ажил үйлсээрээ шалгарч аймаг, хот, байгууллага, салбарын аваргаар шалгарсан ажиллагсад үндсэн цалингийн хэмжээгээс төрийн эрхэм

- 8.8 Ахмадын өдөр, сар шинийн баяраар ахмад настнаа баярлуулах, хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 8.9 Ажилтан өөрөө болон гэр бүлийн гишүүн буюу эхнэр, нөхөр, үр хүүхэд нь магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын шийдвэрээр ЭМС-н тушаалаар батлагдсан Монгол улсад эмчлэгдэх боломжгүй өвчний жагсаалтад батлагдсан зайлшгүй гадаад улсад эмчлүүлэх болсон тохиолдолд албан хаагчийн хүсэлтээр 1 удаагийн буцалтгүй тусламж үзүүлнэ.
- 8.10 Байгууллагын нэрийг гарган улс, бүсийн чанартай тэмцээнүүдэд ганцаарчилсан болон багаараа оролцсон тохиолдолд байгууллагаас дэмжлэг үзүүлнэ.
- 8.11 Ажилтануудын өдрийн хоолны мөнгийг хуваарилсан төсөвт багтаан сар бүр олгоно. Эмч ажилчдын хоолны мөнгийг ЭМС-н тушаалд заасны дагуу 5000 төгрөгөөс доошгүйгээр олгох ба эмч, ажиллагсадын хоолны газартай болж хөнгөлөлттэй үнээр үйлчлэх, Хөнгөлөлттэй үнээр олгосон хоолны зардлыг ҮЭХ-ны дансанд төвлөрүүлнэ.
- 8.12 БОЭТөвийн эмч ажилчид эмнэлэгт үзүүлж эмчлүүлэхэд дугаар харгалзахгүй үйлчилж хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд 1 хүнд жилд 1 удаа ЭМД үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан хувь хүний төлөх мөнгийг төлүүлэхгүйгээр эмчилнэ.
- 8.13 Ажилтаны ар гэрт байгалийн аливаа гамшиг, гал усны гэнэтийн аюул тохиолдон орон гэргүй болсон үед тухайн нөхцөл байдлыг үнэлэн буцалтгүй тусламж үзүүлнэ.
- 8.14 Байгууллагын төсвийн хэмнэлт болон өөрийн үйл ажиллагаанаас орох орлогын төлөвлөгөөг давуулсан тохиолдолд байгууллагын ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, урамшуулал олгох, нийгмийн асуудлыг шийдвэрлэх.
- 8.15 Эмнэлгийн ажилтан өөрөө хүндээр өвдөж акт аваад хуулийн хугацаа дууссаны дараа ХЧА-г тогтоолгон дахин ажиллахгүй тохиолдолд 1 сарын үндсэн цалин олгоно.

ЕС. ЭМЧ АЖИЛЧДАД ҮЭ-ИЙН ХОРООНЫ САНХҮҮЖИЛТЭЭС ҮЗҮҮЛЭХ НИЙГЭМ АХУЙН ХӨНГӨЛӨЛТ (ТУСЛАМЖ, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ)

- 9.1 ҮЭ-ийн гишүүн ажилтан нь улсын чанартай магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд сувиллуулсан сувиллын төлбөрийн баримт, илгээх карт болон бусад баримтыг үндэслэн ҮЭ-ийн хорооноос 250,000 төгрөг олгоно. / жилд 1 удаа, ажиллах хугацаанд нь 3 удаа олгоно/
- 9.2 Гэр бүлийн гишүүд /эхнэр, нөхөр, хүүхэд болон төрсөн, хадам эцэг эх / нас барсан тохиолдолд нас барсан гэрчилгээг үндэслэн 200,000 төгрөгний тусламж олгоно. Нэг гэр бүлийн хүмүүс ажиллаж байгаа тохиолдолд адил хамаарна.
- 9.3 Байгалийн онц аюултай үзэгдэлд / салхи, шуурга, гал түймэр, үер усны аюул / өртсөн ҮЭ-ийн гишүүний өрхөд зохих бичиг баримтыг үндэслэн 500,000 төгрөгний тусламж өгнө.
- 9.4 Ажиллагсадын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор биеийн тамир спортын арга хэмжээг нийт ажиллагсдын дунд зохион байгуулж, ҮЭ-ийн хорооноос 10,000,000 хүртэл төгрөг жилдээ зарцуулна.
- 9.5 Хөдөлмөрийн харилцаатай холбоотой зөрчил гарсан үед ҮЭХ-оос ажилтаны эрх ашгийг хамгаалж, хууль зүйн зөвлөлгөө авах ба өмгөөллийн туслалцаа үзүүлнэ.
- 9.6 МҮЭ, МЭМАҮЭ Холбооны шагналаар шагнагдсан болон ҮЭ-ийн хорооны ажилд идэвхи санаачлагатай оролцсон гишүүдийг 50000 төгрөгөөр шагнана.
- 9.7 Ажилчдын ЭМ-г дэмжих зорилгоор чийрэгжүүлэлтийн танхимтай болгох буюу идэвхитэй хөдөлгөөн хийх ажлыг өрнүүлэх, эрүүлжүүлэхэд зориулсан санхүүжилтийг олгоно.
- 9.8 Ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, спортоор хичээллэхэд нь анхаарч спорт заалтай гэрээ байгуулан төлбөрийг санхүүжүүлэн хяналт тавьж ажиллана.
- 9.9 Ажилчдын нийгэм ахуйн хангамжид зориулсан зорилтот бүлэгт тухайн тохиолдолд тэргүүлэгчээр хуралдаж тогтоол шийдвэр гаргах журамаар зохицуулна.

**АРАВ. ЭМЧ АЖИЛЧДАД БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРГАА, ҮЭ-ИЙН
ХОРООНООС ХАМТРАН ҮЗҮҮЛЭХ НИЙГЭМ АХУЙН ХӨНГӨЛӨЛТ 50%:50% (ТЭТГЭМЖ,
УРАМШУУЛАЛ)**

- 10.1 Ажилтаны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор ҮЭ-ийн хороо байгууллагын захиргаатай хамтран нийт эмч ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт оруулах ажлыг тухайн жилийн эхний хагас жилд багтаан зохион байгуулж өвчтэй хүмүүсийг хэвтэн эмчлүүлэх,эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 10.2 Ажилчдын ар гэр / өндөр настай, хэвтрийн өвчтэй / эмээ, өвөө, аав, ээжийг нь жилд 1 удаа нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.
- 10.3 Эмзэг бүлэгт хамаарагдах ажиллагсдад /өрх толгойлсон 0-16 насны 4-с дээш хүүхэдтэй ажилтан/тэтгэлэг тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулахад төрийн бус байгууллагын тусалцаа авах ажлыг хамтран зохион байгуулж тусламж олгож болно.
- 10.4 Эмч, сувилагч, эх баригч нарын баяр, эмнэлгийн ажилчдын баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд үйл ажиллагааг хамтран зохион байгуулна.
- 10.5 Өндөр насны тэтгэвэрт гарч буй ажилтанд хүндэтгэл үзүүлнэ.

АРВАН НЭГ. ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ЭРХИЙГ ХАНГАХ ТАЛААР.

- 11.1 БОЭТөвийн захиргаа нь байгууллагын ҮЭ-ийн хороо түүний дарга тэргүүлэгчдийг үйл ажиллагаа явуулахад нь тусалж дэмжин / ажлын өрөө, ширээ сандал, хурал хийх байраар хангах /хамтын гэрээний төсөл боловсруулах,хэлэлцээ хийх болон бусад үйл ажиллагаа явуулахад төсөв санхүүгийн шаардлагатай мэдээ тайлан судалгааг гаргаж өгөх үүрэг хүлээн хамтарч ажиллана.
- 11.2 ҮЭ-ийн гишүүдийн татварыг үндсэн цалингийн 1%-иар бодож, цалингаас суутгаж дараа сарын 5 ны дотор ҮЭ-ийн хорооны дансанд шууд шилжүүлнэ.
- 11.3 Захиргаа нь үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй ҮЭХ-ийн дарга тэргүүлэгчдэд 14 хоногт 2-3 цагийг 1 удаа ажил үүргээ гүйцэтгэхэд нь зориулан гаргаж өгнө.
- 11.4 ҮЭ-ийн идэвхтэн, сонгуульт ажилтан ҮЭ-н сургалтанд хамрагдах, хурал зөвлөгөөн, сургалт, ярилцлаганд оролцох үед чөлөө олгож цалин хөлсийг хэвээр олгоно.
- 11.5 Байгууллагын дэргэдэх Хөдөлмөрийн маргаан таслах, Үйлдвэрлэлийн ослыг тогтоох, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны, ёс зүйн хорооны зэрэг орон тооны бус комиссуудын бүрэлдэхүүнд ҮЭ-ийн төлөөлөл оролцож хамтран ажиллана.
- 11.6 Байгууллагын төсвийн төсөл боловсруулах,хэлэлцэн батлах,ажилтныг ажилд авах,ажлаас халах,цалин хөлсний болон бусад нийгмийн асуудлуудыг хэлэлцэж шийдвэр гаргах түвшинд ҮЭ-ийн төлөөлөлийг оролцуулна.
- 11.7 ҮЭ-ийн гишүүдийн хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг нь хөндөх аливаа шийдвэрийг гаргахдаа хоёр долоо хоногоос доошгүй хугацааны өмнө ҮЭ-ийн хороонд танилцуулж саналыг нь тусгаж байна.
- 11.8 ҮЭХорооны сонгуульт ажилтнуудад урамшуулалыг МЭМАҮЭХолбооны 11 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар зохицуулна.
- 11.9 Үйлдвэрчний эвлэлийн хорооны сонгууль хугацаа нь 3 жил байна.

**АРВАН ХОЁР. ХАМТЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭНД ХЯНАЛТ ТАВИХ, ТҮҮНД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА**


- 12.1 Хамтын гэрээний биелэлтэнд талууд болон тэдгээрийн төлөөлөгчид хяналт тавина.
- 12.2 Хамтын гэрээг зөрчсөн буюу гэрээг биелүүлээгүй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хууль

тохирсон асуудлыг цуцлах үндэслэл болохгүй.

- 12.5 Хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг сонирхогч аль нэг тал нь хоёр 7 хоногоос доошгүй хугацааны өмнө бичгээр гарган нөгөө талтай хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 12.6 Энэхүү хамтын гэрээ нь бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж дараагийн хамтын гэрээг байгуулах хүртэл 2 жилийн хугацаанд хүчинтэй хэвээр мөрдөгдөнө.
- 12.7 Энэхүү гэрээний хавсралт болгон дор дурьдсан баримт бичгийг ажил олгогч ҮЭХороотой зөвшилцсөнөөр баталж мөрдүүлнэ:
- a) Хөдөлмөрийн дотоод журам
 - b) Ажил албан тушаалын жагсаалт
 - c) Ажлын байрны тодорхойлолт болон албан тушаалын лавлах
 - d) Хөдөлмөрийн норм норматив
 - e) Үндсэн цалингийн сүлжээ, жишиг
 - f) Ажилтанд олгох нэмэгдлийн төрөл, олгох нөхцөл
 - g) Шагнал урамшуулал олгох журам
 - h) Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд олгох хор саармагжуулах шингэн, хоол, хүнсний бүтээгдэхүүний жагсаалт, түүнд хамаарагдах ажил мэргэжлийн жагсаалт
 - i) Ажилтанд олгох хувцас хамгаалах хэрэгслийн төрөл, жагсаалт, эдэлгээний хугацаа, норм, тэдгээрийг угааж ариутгах хугацаа хуваарь
 - j) Бусад жагсаалт журам.
 - k) Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ

1. БОЭТөвийн захирал
 Д. Дашжанцан
2. Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
 Д. Болормаа
3. Хуулийн зөвлөх
 Д. Анхбаяр

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООГ ТӨЛӨӨЛЖ

1. Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
 Д. Мөнхнасан
2. ҮЭХ-ны тэргүүлэгч
 Д. Ганбат
 Б. Сувд-Эрдэнэ
 Д. Төмөрцөөж
 Д. Наранхүү